



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 05 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 05 дугаар хуралдааныг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний орчны үнэлгээ, судалгааны үр дүн, ХХЗХ-ноос 2023 онд нээлттэй шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоон батлах тухай (Хорооны 2022 оны 12 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт); ХЗДХЯ-ны санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх тухай (Хорооны 2023 оны 22 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэн хорооны 6 тогтоолыг баталсан юм.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдааны 12 дугаар хуралдааны тэмдэглэлээр Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний орчны үнэлгээ, судалгааны үр дүн, ХХЗХ-ноос 2023 онд нээлттэй шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоон батлах тухай асуудлыг боловсруулан Хорооны хуралдаанд 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг тус хорооны ӨНЗГ-т даалгасан болно.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9 дэх заалтаар тус тус тогтоосон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “*Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.*” гэж; 7 дугаар зүйлийн 7.4.2-т “*өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх;*” гэж; 7.4.5-д “*энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;*” гэж; 30 дугаар зүйлийн 30.1.9-д “*өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;*” гэж; 30.1.10-т “*хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;*” гэж тус тус тодорхойлсны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан юм.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай

зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох журмыг тусгаж, Харилцаа холбооны зохицуулах хороо 2020 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг тус хорооны 2023 оны 02 тоот тогтоолоор хүчингүй болгосон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.” гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх нэр бүхий төрлийн тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгох эрх зүйн орчин бүрдсэн.

Хорооны 2022 оны 12 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 заалтыг тус тус үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”-г хуулиар олгогдсон үйлчилгээний төрөлд тогтооход шаардлагатай Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгааны үр дүн, тоо тогтоох тухай үндэслэл, танилцуулга, тогтоолын төслийг тус тус боловсруулан Хорооны 2023 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэв. Үүнд: Монгол Улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл; Дорноговь аймагт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл; Говьсүмбэр, Дундговь, Булган, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тус бүр 1, нийт 7 тусгай зөвшөөрөл; Хэнтий аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл; Баянхонгор, Булган, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Дорноговь, Өвөрхангай (Хархорин сум) аймагт радиогийн үйлчилгээ эрхлэх тус бүр 1, нийт 10 тусгай зөвшөөрлийн тоог тус тус тогтоохоор саналыг боловсруулсан болно. Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтооход ӨНЗГ-ын хийсэн судалгаа, эрэлт хэрэгцээ; Радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай тохиолдолд радио давтамжийн төлөвлөлт, нөөц; Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой нөхцөлийг тодорхойлох, Радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээний сувгийн багтаамж, нөхцөл байдал зэргийг харгалзан үзсэн байна. Хорооны хуралдаанаас уг асуудлыг авч хэлэлцээд, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 35 тоот “Тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан. Тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах хугацаа”-г тогтоож шийдвэрлэсэн. Уг тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны 35 тоот тогтоол, хавсралтад заасан сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацааг баримтлан зохион байгуулах бөгөөд 2023 оны 2-3 дугаар улиралд багтаан зарлаж, дүнг Хорооны ээлжит хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд 2023 онд багтаан сонгон шалгаруулалтыг дахин зарлахыг холбогдох бүтцийн нэгжийн удирдлагад даалгав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар баталсан 2023 оны 22 тоот тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний улсын актын бүртгэлд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлсэн ба уг тогтоолын талаар ХЗДХЯ-наас албан тоотоор ирүүлсэн санал, зөвлөмжийг үндэслэн тус хорооны Хуулийн хэлтэс, ЗУХАГ, ШЗГ-аас хамтран нэгдүгээрт, ХХЗХ-ны 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 22 тоот тогтоолын үндэслэлд “Харилцаа холбооны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг”-ийг шинээр нэмж оруулан дараах байдлаар өөрчлөлт оруулах саналыг “Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь: ...”; хоёрдугаарт, “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага”-ын /Шуудангийн сүлжээ байгуулах 1.3 дахь заалтыг хасах редакцын өөрчлөлт оруулах саналыг тус тус хэлэлцэн дэмжиж, холбогдох өөрчлөлтийг оруулан тогтоолыг батлахаар шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.12 болон 9.14 дүгээр заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 36 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 37 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 38 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 39 тоот тогтоолын хавсралтаар 13 хуулийн этгээдийн 16 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт болон Эм эс жи эм ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 40 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-04-28